

**МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
САНГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН  
САНГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХОЁР ДАХЬ  
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ ХИЙСЭН ТАЛААРХ ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 11 дүгээр  
сарын 02, 03-ны өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын чуулганы 2022 оны 10 дугаар сарын 06, 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хийж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр бүх Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын даргын 2022 оны 151 дүгээр захирамжаар төсвийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгээр ахлуулан ажлын хэсгийн байгуулан ажиллуулсан бөгөөд тус ажлын хэсгээс төсвийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хүрээнд дэд ажлын хэсгийг байгуулан ажиллуулж, саналуудыг нэгтгэн хэлэлцлээ.

Улсын Их Хурлын бусад Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо өөрийн эрхлэх асуудлынхаа хүрээнд төсвийн төслийг хэлэлцээд санал тус бүрээр санал хураалт явуулж олонхын дэмжлэг авсан, аваагүй хэсгээр нь бүлэглэн томьёолж, зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт Төсвийн байнгын хороонд ирүүлсэн.

Төсвийн байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 02, 03-ны өдрүүдийн хуралдаанаараа төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийж, Төсвийн байнгын хорооны гишүүд, түүнчлэн бусад Байнгын хороо, төсвийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгээс гаргасан санал нэг бүрийг хэлэлцэж ил санал хураалт явуулж, олонхын дэмжлэг авсан, аваагүй хэсгээр нь бүлэглэн томьёолж, зарчмын зөрүүтэй саналын томьёолол бэлтгэсэн.

Түүнчлэн Улсын Их Хурлын Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсээс төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан төсвийн санал нь Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын дүнг нэмэгдүүлээгүй байх, Төсвийн тухай хуулийн 6.2.6, 29.3, 29.4-т заасан шаардлагыг хангасан эсэх талаар дүн шинжилгээ хийж, гарсан дүгнэлт зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг нэгдсэн хуралдаанд танилцуулахаар Та бүхэнд тараасан болно.

Төсвийн ажлын хэсэг болон Төсвийн байнгын хорооноос Засгийн газрын өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд өөрчлөлт оруулахаар дараах зарчмыг баримталсныг нийт хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно. Үүнд:

1.Төсвийн тэнцэл сайжруулахтай холбогдуулан төсвийн орлогыг 130.0 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 0.23 хувиар сайжруулахаар санал бэлтгэлээ.

2.Эдийн засгийн хүндрэлтэй цаг үед төсвийн ерөнхийлөн захирагчдын үйл ажиллагааны зардал, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээний зардал, гадаад зээл тусламжтай холбоотой зарим шаардлагагүй зардлыг бууруулж, 170.0 орчим тэрбум төгрөгийн төсвийн хэмнэлт бий болгох саналыг бэлтгэв.

3.Зарим шаардлагагүй зардлыг бууруулсан эх үүсвэрээр нийгмийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авахаар санал бэлтгэлээ. Тухайлбал, улсын хэмжээнд гэр хорооллын айл өрхөд цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлтийн зардалд шаардагдах урсгал зардлыг нэмэгдүүлэх, "Элэг бүтэн Монгол" үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлэхэд шаардагдах урсгал зардлыг нэмэгдүүлэх, Ойн хортон шавжтай тэмцэх ажилд шаардагдах урсгал зардлыг нэмэгдүүлэх, Хүүхэд хамгаалах арга хэмжээ болон Өнөр бүл хүүхдийн төвийн урсгал зардал, сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хүнсний хангамж, аюулгүй байдал зэрэг нийгэм, эдийн засагт үүссэн хүндрэлтэй асуудлуудыг зохицуулахаар санал бэлтгэн танилцуулж байна.


Зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2023 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хуулийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА**



**Г.ТЭМҮҮЛЭН**